

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Цэнхэр сумын цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/089/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139, Утас/Факс: (976) 7033 3141, Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn	АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН Г.ХОРОЛСҮРЭН ТАНАА
2025.02.25 № 109 танай _____-ны № _____-т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цэнхэр сумын цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Аудитын гол асуудал</p> <p>Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 966,327.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 746,856.8 мянган төгрөгийг зарцуулан, 221,570.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.</p> <p>Бусад асуудлын хэсэг</p> <p>Архангай аймгийн Цэнхэр сумын цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна.</p>	

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	178,574,444.01	295,111,243.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	121,421,105.37	221,570,875.10
312	Банканд байгаа бэлэн мөнгө	121,421,105.37	221,570,875.10
3121	Төгрөг	121,421,105.37	221,570,875.10
31211	Төрийн сангийн харилцах	121,421,105.37	221,570,875.10
33	АВЛАГА	348,900.00	-
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	348,900.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	56,804,438.64	73,540,368.64
351	Түүхий эд материал	48,919,733.64	59,503,533.64
3511	Тусгай зориулалттай материал	46,056,233.64	56,640,033.64
3513	Эм боох материал	2,863,500.00	2,863,500.00
354	Хангамжийн материал	7,884,705.00	14,036,835.00
3541	Бичиг хэргийн материал	1,089,220.00	1,295,220.00
3542	Аж ахуйн материал	5,446,485.00	10,325,115.00
3545	Барилга засварын материал	1,349,000.00	2,416,500.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	246,511,237.38	256,538,475.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	246,511,237.38	256,538,475.82
392	Биет хөрөнгө	215,519,237.38	225,546,475.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	233,646,634.00	233,646,634.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-42,193,971.28	-48,325,851.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,384,510.00	62,207,890.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-31,283,882.04	-34,873,568.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,555,747.00	29,196,147.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,234,226.86	-17,831,201.87
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,736,180.00	5,736,180.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,510,680.18	-5,628,680.01
39217	Ном	1,418,926.74	1,418,926.74
393	Биет бус хөрөнгө	30,992,000.00	30,992,000.00
39301	Программ хангамж	650,000.00	650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,342,000.00	30,342,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	425,085,681.39	551,649,719.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,706,590.80
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,706,590.80
413	Өглөг	-	1,706,590.80
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,706,590.80
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	425,085,681.39	549,943,128.76
51	Засгийн газрын хувь оролцоо	425,085,681.39	549,943,128.76
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	168,990,231.95	168,990,231.95
512	Хуримтлагдсан үр дүн	253,497,204.44	378,354,651.81
5121	Өмнөх үеийн үр дүн	253,497,204.44	253,497,204.44
5122	Тайлант үеийн үр дүн	-	124,857,447.37
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,598,245.00	2,598,245.00

Архангай аймгийн Цэнхэр сумын цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	425,085,681.39	551,649,719.56
----	--	----------------	----------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	638,926,900.00	866,781,980.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,483,500.00	19,454,880.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,483,500.00	19,454,880.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,483,500.00	19,454,880.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,683,500.00	17,404,880.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	2,800,000.00	2,050,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	632,443,400.00	847,327,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	606,368,200.00	812,521,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	606,368,200.00	812,521,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,075,200.00	34,805,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,075,200.00	34,805,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	550,419,509.64	741,924,532.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,419,509.64	741,924,532.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,181,009.64	741,603,995.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,261,187.30	540,485,334.54
210101	Үндсэн цалин	244,667,153.60	378,003,212.16
210102	Нэмэгдэл	94,974,336.70	140,395,005.13
210104	Урамшуулал	14,619,697.00	22,087,117.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,856,349.01	67,066,597.73
210201	Тэтгэврийн даатгал	30,973,148.79	45,739,685.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,619,654.80	5,451,944.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,043,691.17	2,999,175.07
210204	Ажилгүйдлийн даатгал	645,502.40	2,565,359.33
210205	Эрүүл мэндийн даатгал	6,574,351.85	10,310,433.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,945,500.00	31,191,953.80
210301	Гэрэл, цахилгаан	3,050,000.00	3,513,263.00
210302	Түлш, халаалт	14,895,500.00	25,978,690.80
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,378,806.05	200,000.00
210408	Бараа материал акалсны зардал	5,378,806.05	200,000.00
2105	Нормативт зардал	72,659,100.00	65,314,298.00
210502	Хоол, хүнс	72,659,100.00	65,314,298.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,644,500.00	3,559,500.00
210604	Урсгал засвар	3,644,500.00	3,559,500.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,267,500.00	1,251,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,267,500.00	1,251,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,168,067.28	32,535,311.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,263,171.82	13,296,070.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,524,636.00	7,802,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	17,380,259.46	11,436,541.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,238,500.00	320,537.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,238,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,238,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	320,537.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	320,537.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	88,507,390.36	124,857,447.37
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	88,507,390.36	124,857,447.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	632,443,400.00	847,327,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	632,443,400.00	847,327,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	606,368,200.00	812,521,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	606,368,200.00	812,521,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,075,200.00	34,805,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,075,200.00	34,805,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	539,836,636.31	743,118,430.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	539,836,636.31	743,118,430.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,598,136.31	742,797,893.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,610,087.30	540,136,434.54
210101	Үндсэн цалин	244,667,153.60	378,003,212.16
210102	Нэмэгдэл	94,974,336.70	140,395,005.13
210104	Урамшуулал	14,968,597.00	21,738,217.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,856,349.01	67,066,597.73
210201	Тэтгэврийн даатгал	30,973,148.79	45,739,685.58
210202	Тэтгэмжийн даатгал	3,619,654.80	5,451,944.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,043,691.17	2,999,175.07
210204	Ажилгүйдлийн даатгал	645,502.40	2,565,359.33
210205	Эрүүл мэндийн даатгал	6,574,351.85	10,310,433.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,075,200.00	29,485,363.00
210301	Гэрэл, цахилгаан	3,050,000.00	3,513,263.00
210302	Түлш, халаалт	17,025,200.00	24,272,100.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,700,000.00
2105	Нормативт зардал	72,659,100.00	65,314,298.00
210502	Хоол, хүнс	72,659,100.00	65,314,298.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,267,500.00	2,458,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,267,500.00	2,458,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,129,900.00	33,336,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,327,500.00	25,533,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,802,400.00	7,802,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,238,500.00	320,537.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,238,500.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,238,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	320,537.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	320,537.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	92,606,763.69	104,208,669.73
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,058,900.00
	Дотоод эх үүсвэрээр	-	4,058,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	4,058,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-4,058,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	92,606,763.69	100,149,769.73
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	121,421,105.37
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	221,570,875.10

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	164,989,814.08	336,578,291.03
7	Тайлант үеийн үр дүн			88,507,390.36	88,507,390.36
10	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	253,497,204.44	425,085,681.39
17	Тайлант үеийн үр дүн			124,857,447.37	124,857,447.37
19	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	168,990,231.95	2,598,245.00	378,354,651.81	549,943,128.76

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	966,327,000.00	746,856,793.27	219,470,206.73	77.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,327,000.00	746,856,793.27	219,470,206.73	77.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	966,327,000.00	746,856,793.27	219,470,206.73	77.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	730,589,000.00	540,136,434.54	190,452,565.46	73.93
210101	Үндсэн цалин	515,922,200.00	378,003,212.16	137,918,987.84	73.27
210102	Нэмэгдэл	203,576,200.00	140,395,005.13	63,181,194.87	68.96
210104	Урамшуулал	11,090,600.00	21,738,217.25	-10,647,617.25	196.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,811,300.00	67,066,597.73	15,744,702.27	80.99
210201	Тэтгэврийн даатгал	56,313,800.00	45,739,685.58	10,574,114.42	81.22
210202	Тэтгэмжийн даатгал	6,622,700.00	5,451,944.37	1,170,755.63	82.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,312,400.00	2,999,175.07	313,224.93	90.54
210204	Ажилгүйдлийн даатгал	3,312,400.00	2,565,359.33	747,040.67	77.45
210205	Эрүүл мэндийн даатгал	13,250,000.00	10,310,433.38	2,939,566.62	77.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,805,900.00	29,485,363.00	320,537.00	98.92
210301	Гэрэл, цахилгаан	3,833,800.00	3,513,263.00	320,537.00	91.64
210302	Түлш, халаалт	24,272,100.00	24,272,100.00		100
210303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	1,700,000.00		100
2105	Нормативт зардал	75,082,900.00	65,314,298.00	9,768,602.00	86.99
210502	Хоол, хүнс	75,082,900.00	65,314,298.00	9,768,602.00	86.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,458,900.00	2,458,900.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,458,900.00	2,458,900.00	-	100

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,579,000.00	37,395,200.00	3,183,800.00	92.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,776,300.00	29,592,500.00	3,183,800.00	90.29
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,802,700.00	7,802,700.00	-	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	966,327,000.00	847,006,563.00	119,320,437.00	87.65
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	812,521,200.00	812,521,200.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	812,521,200.00	812,521,200.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,805,900.00	34,485,363.00	320,537.00	99.08
132001	Орон нутгийн төсвөөс	34,805,900.00	34,485,363.00	320,537.00	99.08
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	118,999,900.00		118,999,900.00	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	118,999,900.00		118,999,900.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		121,421,105.37	-121,421,105.37	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		221,570,875.10	-221,570,875.10	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.00
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	26.50	26.50		100.00
6	Удирдах ажилтан	1.00	1.00		100.00
7	Гүйцэтгэх ажилтан	8.50	8.50		100.00
8	Үйлчлэх ажилтан	17.00	17.00		100.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй. Харин аудитаар залруулагдаагүй 2,950.5 мянган төгрөгийн зөрчил илэрч, 1,243.9 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 1,706.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илэрсэн зөрчил нь гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 10,871.1 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1. Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд өндөр насны тэтгэвэрт гарсан 2 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж, нийт 1,243.9 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

3.2. Албан шаардлага

3.2.1. Харилцагч байгууллагуудтай тухай бүр авлага, өглөгийн тооцоо нийлээгүйгээс жилийн эцэст 1,706.6 төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 -т 'эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр, дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах' гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

3.2.2. Аймгийн ЗДТГ-ын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 08/1569 дүгээр албан бичгээр "Г.Баярсайханыг нягтлан бодогчоор ажиллуулах зөвшилцөх боломжгүй" гэсэн мэдэгдлийг ирүүлсэн байхад Цэнхэр сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн Б/37 дугаар тушаалаар Г.Баярсайханыг нягтлан бодогчийн ажилд 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн түр томилон ажиллуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 19.6-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагч нь төсвийн ахлах нягтлан бодогчийг дараах байдлаар зөвшилцөн томилж, чөлөөлнө", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 зүйлийн 3.1.7 дахь заалтын дагуу магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн байх", 2.1.5-д "Нягтлан бодогчоор 2 доошгүй жил ажилласан бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1. Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

3.3.2. Няравын программ ашиглалт, анхан шатны баримтын боловсруулалт, бараа материалын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд

оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд нярвын программыг ашиглалтыг сайжруулж бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

Зөвлөмжийн биелэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, холбогдох нотлох баримтыг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн нэмэгдэлтэй холбоотой	1	1,243.9	1	1,243.9								
Өр төлбөртэй холбоотой	1	1,706.6			1	1,706.6						
Шаардлага хангаагүй томилгоо хийсэн	1								1	1		
Програмтай холбоотой	1	0					1	0				
Бараа материалтай холбоотой	1	0					1	0				
Дүн	5	2,950.5	1	1,243.9	1	1,706.6	1	0	1	1		